

ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ЭРДЭНЭБААТАР ОВОГТОЙ АМАРБАЯСГАЛАНГИЙН СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Сонгуулийн уриа: Эрдэнэтчүүд бид эхлүүлж чадна.

Энэхүү мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудын хүрээнд боловсруулагдсан ба хэрвээ ИТХ-д сонгогдсон тохиолдолд төлөөлөгчийн хувьд Эрдэнэт хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх зорилтот ажлууд мөн тухайн нэр дэвшигчийн нэр дэвших баг дээр хийж хэрэгжүүлэх, шийдвэрлэх зорилтуудыг 2 хэсэгт багтаан томъёолж өгсөн болно.

Зорилт 1. Эрдэнэт хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд.

1.1. Эрдэнэт хотын иргэд байгалийн баялагтаа эзэн байх, үр шимийг нь хүртдэг байх талаар Эрдэнэт хотоос УИХ-д сонгогдсон гишүүдтэй хамтран ажиллаж, эрх зүйн орчинг нь бүрдүүлнэ.

1.2. Ажил хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг ажлын байраар хангах, ажлын байр олноор бий болгох тал дээр бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

1.3. Иргэдийн амьжиргааг дэмжих, бага орлоготой иргэдэд чиглэсэн тусгай хөтөлбөр боловсруулж өөрсдийнх нь оролцоог хангаж хэрэгжүүлнэ.

1.4. Ажлын байр нэмэгдүүлэх гол эх үүсвэр нь жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг олноор бий болгохтой холбогдох ба энэ чиглэлд ЖДҮ сан болон бусад дэмжлэгийн сангудын үйл ажиллагааг ил тод хүртээмжтэй байхад анхаарч дэмжиж ажиллана.

1.5. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай Эрдэнэт хотын ИТХ, ЗДТГ-ын зүгээс хамтран ажиллах гэрээг шинэчлэн боловсруулж гадаад улсаас импортоор авдаг бараа бүтээгдэхүүнийг Эрдэнэт хотдоо үйлдвэрлэж байгаа хувь хүн, аж ахуйн нэгжүүдийг бүрэн дүүрэн дэмжиж ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлж хэрэгжүүлнэ.

1.6. Эрдэнэт хотын захиргаа, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд байгаль орчны бохирдол хүн, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй асуудлууд, гол ус, хөрсний бохирдол, Цагаан тоосныг арилгах тал дээр онцгой анхаарч ажиллана.

1.7. Хотын хүн ам есөн нэмэгдэж буйтай холбогдуулан сургууль, цэцэрлэгийн хангалт хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр үе шаттай бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

1.8. Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Медипас зэрэг иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй эмнэлгүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах, зайлшгүй техник, тоног төхөөрөмжөөр хангах, эмч эмнэлгийн ажилтнуудыг давтан сургах, эрүүл мэндийн үйлчилгээг иргэд саадгүй түргэн шуурхай авч байх тал дээр анхаарч ажиллана.

1.9. Иргэдэд анхан шатны эмнэлгийн тусламж үзүүлдэг Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байр, техник, тоног төхөөрөмжтэй болгоход онцгой анхаарч үе шаттай шийдвэрлэнэ.




Э.Дамар  
Г.Дамар

- 1.10. Гэр хороололд амьдарч буй иргэдэд агаар хөрсний бохирдлыг арилгах тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цэвэр, бохирын шугам, халаалтын асуудлыг шийдвэрлэх чиглэлээр УИХ, ЗГ, холбогдох яамд, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж эхлүүлнэ.
- 1.11. Хогны менежментийг сайжруулж, хог боловсруулах үйлдвэрийг дэмжиж ажиллана.
- 1.12. Орон сууцны хорооллуудын авто зам, зогсоол, явган замыг өргөтгөж, зохион байгуулалтыг сайжруулж, нэвтрүүлэх чадавхыг дээшлүүлэх, Гэр хорооллын асфальтан болон сайжруулсан авто болон явган замыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
- 1.13. Эрүүл зөв хэрэглээг дэмжих зорилгоор хотын төв болон бусад хэсэгт дугуйн замтай болох ажлыг эхлүүлж мэргэжлийн байгууллагаар зураг төсөл, холбогдох судалгааг хийлгэж, эхлүүлнэ.
- 1.14. Нийтийн тээврийн үйлчилгээний менежментийг сайжруулж, тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх тал дээр анхаарна. Хот хоорондын зорчигч тээврийн Авто вокзалтай болох асуудлыг холбогдох чиглэлээр нь хамтран хэрэгжүүлнэ.
- 1.15. Нийтийн биеийн тамир, спортыг дэмжих хүрээнд үйл ажиллагаа явуулж буй клубүүд, спортын холбоодын зохион байгуулалтыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.16. Хүүхэд багачууд чөлөөт цагаа өнгөрөөх, чийрэгжүүлэх тоглоомын талбайг хотын төвийн болон гэр хорооллын багуудаар үргэлжлүүлэн хийнэ.
- 1.17. Хотын ДЦС-ын өргөтгөл хийгдэж, Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал нэмэгдэж байгаатай холбогдуулан хотын хуучирсан инженерийн шугам сүлжээг үе шаттай солих ажлыг эхлүүлнэ.
- 1.18. Ахмад, Эмэгтэйчүүд, Залуучууд, Хүүхдүүд рүү хандсан нийгмийн харилцааг зохицуулах, дэмжсэн дэд хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.19. Өндөр настан, харж хандах хүнгүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү хандсан нийгмийн дэмжлэгийг чирэгдэлгүй хүргэх тал дээр онцгойлон анхаарч ажиллана.
- 1.20. Орон нутгийн дотоод зах зээлээ хамгаалах, хүнс, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдалд онцгой анхаарч эрх зүйн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.21. Эрдэнэт хотыг үер усны болзошгүй аюулаас хамгаалах үерийн хамгаалалтын далан барих асуудалд онцгой анхаарч дэмжиж ажиллана.
- 1.22. Хотын иргэдийн аюулгүй байдалд анхаарч камержуулалтын системийг төгөлдөржүүлэх, гудамж талбайн хаягийг нэгдсэн стандартад оруулах
- 1.23. Хууль сахиулах онцгой чиг үүрэг бүхий байгууллагуудыг шаардлагатай техник хэрэгслээр дэмжиж, бэлэн байдлыг хангуулахад хамтран ажиллана.
- 1.24. Орхон аймаг нь Эрдэнэт хот болж байгаатай уялдуулан Хотын соёлыг түгээх, шинэ цаг үеийн хотын иргэд, хотын залуус байх аливааuriалгыг нийгэмд түгээж, ажиллах сайн санал, санаачлагыг дэмжиж хамтран ажиллана.

Зорилт 2. Багийн хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд.

- 2.1. Хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллын багийн зарим хэсгийг инженерийн шугам сүлжээнд холбон амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.



2.2. Орон сууцны байрнуудын дээвэр, заадсын засвар, халаалт дулааны алдагдлыг чанартай, түргэн шуурхай, баталгаатай гүйцэтгэдэг байх нөхцөлийг бурдуулж оршин суугчид өөрсдөө хяналт тавьдаг зохицуулалтыг хангана.

2.3. Орон сууц болон гэр хорооллын дунд байрлах хүүхдийн тоглоомын талбайн ашиглалтыг сайжруулах, засаж янзлах, үе шаттай нэмэгдүүлэхэд онцгой анхаарна.

2.4. Байр, гэр хороолол хоорондын авто замын нэвтрүүлэх чадавхыг нэмэгдүүлж, өргөтгөх, авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх, явган замыг сайжруулах, үерийн ус зайлцуулах шугамын ажлыг хийх асуудлыг шийдвэрлэнэ.

2.5. Багийн иргэдэд үйлчилгээ үзүүлдэг багийн ЗД-ын ажлын алба, Цагдаагийн хэсэг, Өрхийн эмнэлгийн ажиллах нөхцөлийг сайжруулж, иргэдэд төрийн үйлчилгээг хүнд сурталгүй түргэн шуурхай хүргэдэг зохицуулалтыг бий болгоно.

2.6. Багийн хэмжээнд ахмад настны хөгжлийн төв, залуусын чөлөөт цагийн төв, нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх төв, эцэг эхчүүд гэр бүлд зориулсан төв байгуулах зэрэг аливаа үүсгэл санаачлагыг дэмжиж ажиллана.

2.7. Багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудтай нягт уялдаатай ажиллаж бодлогоор дэмжинэ.

2.8. Багийн харьяалал бүхий ажил хөдөлмөр идэвхтэй хайж байгаа иргэдэд туслах зорилго бүхий Хөдөлмөрийн бирж ажиллуулах бодлого зохицуулалт хийнэ.

2.9. Багийн нутаг дэвсгэрт буй ногоон байгууламжийг арчилж тордох, цаашид үе шаттай нэмэгдүүлж, багийн иргэд өөрсдөө оролцож тарьж ургуулдаг боломжийг нээж өгнө.

2.10. Багийн нутаг дэвсгэр дэх сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр байнга анхаарч ажиллана.

2.11. Ахлах ангийн сурагчдын хөгжлийг дэмжсэн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

2.12. Ахмад настан, харж хандах хүнгүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандуулах нийгмийн бүхий л дэмжлэгийг чирэгдэлгүй хүргэх ажилд онцгой анхаарна.

2.13. Гэр хорооллын иргэдийн бие засах нүхэн жорлонгийн нөхцөлийг сайжруулах, дэвшилтэд технологийг нэвтрүүлэх.

Мөрийн хөтөлбөрийг боловсруулсан.....Э.АМАРБАЯСГАЛАН

2020.07.23

